



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 8/32

Улаанбаатар хот

Г Т

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн  
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг тус төвийн Ерөнхий захирал /Н.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 408 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080475



## ЦУС СЭЛБЭЛТ, СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв /цаашид Төв гэх/ нь улсын хэмжээнд цусны донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн төрөлжсөн мэргэжлийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, мэргэжлийн дүгнэлт гаргах лавлагаа төв мөн.

2. Төв нь цусны донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн чиглэлээр лавлагаа тусlamж үзүүлэх, оношилгоо, эмчилгээний заавар, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага болно.

3. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, тушаал шийдвэрийн дагуу явуулна.

4. Төв нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 49 гэсэн хаягтай байна.

5. Төвийн нэрийг англиар "National Center for Transfusion medicine" гэж орчуулна.

6. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

7. Төвийн нэр, үйлчилгээний хамрах хүрээг илэрхийлсэн билэгдэл, туттай байна.

### Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

#### 2.1. Төв үйл ажиллагаандaa дараах зарчмын баримтлана. Үүнд:

- Үйлчлүүлэгч төвтэй, хүnlэг энэрэнгүй, ил тод нээлттэй, тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх;
- Төрийн хуулийг чандлан сахиж, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтийн со зүйн хом хомжоог мордох;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг чандлах;
- Олон улсын нотолгоонд сууринсан дэвшилтэй технологид тулгуурлах;

#### 2.2. Төвийн алсын хараа

Цус сэлбэлт судлалын чиглэлээр ДЭМБ-ын шаардлагыг хангасан Азидаа тэргүүлэгч орнуудын жишигт хүрнэ.

### **2.3. Төвийн эрхэм зорилго**

Донор хадгалалтыг сайжруулж, эмчилгээнд шаардлагатай аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний тэгш, хүртээмжтэй хангамжийг бүрдүүлж, чадварлаг баг, дэвшилтэт технологи, инновацид тулгуурлан, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд оршино.

### **2.4. Төвийн үнэт зүйлс**

- Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- Тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй тусlamж, үйлчилгээ
- Хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, техник, шинэ технологи, материаллаг нөөц
- Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, эрхэм зорилго

## **Гурав. Төвийн эрх, үүрэг**

### **3.1. Төв нь дараах эрхтэй**

1. Төвийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог дээшлүүлэх, хамтран ажиллах;
2. Цусны донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан санал боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;
3. Төв нь эмчилгээ, үйлчилгээ судалгааны чиглэлээр ном товхимол, зөвлөмж, заавар хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;
4. Цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх болон мэргэшүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;
5. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үр дүнг тооцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;
6. Гадаад дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын яжиппягаяг өргөжүүпон, хамтарсан тосол хотолбор, хэрэгжүүлэх судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэж харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах, хэлэлцээ хийх;
7. Харилцан ойлголцлын санамж бичиг, хэлэлцээний хүрээнд мэргэжлийн хүний нөөцийг сургаж бэлтгэх, гадаадын мэргэжилтнээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгчид урих;
8. Тусlamж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
9. Эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах, мөрдүүлэх, албан хаагчдын цалин, нэмэгдэл, урамшууллын хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд тогтоох, хөдөлмөрийн сахилга, ажлын хариуцлага албан хаагчид холбогдох хууль дурмийн дагуу хариуцлага тооцох;
10. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

### **3.2. Төв нь дараах үүрэгтэй**

1. Үндэсний хэмжээнд донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн чиглэлээр лавлагаа тусlamж, үйлчилгээ үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

2. Чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтын хүрээнд хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, эрсдлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжилтийг хангах;

3. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад торолжсон мэргэжлийн лавлагаа тусlamж, үйлчилгээ үзүүлэх;

4. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, хөгжлийн хөтөлбөр, төсөл, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, гүйцэтгэлийг хянах;

5. Цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, цусны донорын мэдээллийн санг бүрдүүлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, нотолгоонд сууринсан бодлого, хөтөлбөр боловсруулах асуудлаар төрийн захиргааны төв болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйгээр хангах;

6. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, ажлын байран дахь сургалтыг тасралтгүй зохион байгуулах, орон нутагт ажиллаж буй мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх;

7. Нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд сайн дурын донорын үйлсийг сурталчлах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

8. Цусны доноор, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, нөөц, хангамжтай холбоотой үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах;

9. Эрдэм судлалын ажлыг дэмжин анагаах ухааны ололт амжилт, оношлогоо- эмчилгээний дэвшилтэт арга, технологийг тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлэх, үр дүнг тооцож ажиллах;

10. Үйл ажиллагаандын мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

11. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

12. Иргэд, үйлчлүүлэгч, албан хаагч, аж ахуйн нэгж, төр олон нийтийн байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх;

13. Ажиллагдын нийгмийн баталгааг хангах, ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байраар хангах;

14. Ажиллагдын мэргэжил, ур чадварт тохирсон цалин хөлс олгож, мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

15. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг сонгон санхүүжүүлэх;

#### **Дөрөв. Төвийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт**

1. Төвийн удирдах дээд албан тушаалтан нь өрөнхий захирал байх ба эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.

2. Төвийн удирдлагын тогтолцоо нь өрөнхий захирал, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

3. Төвийн ерөнхий захирал нь холбогдох алба, тасгийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, хуулийн зөвлөх, Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4. Төв нь эрдэм, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн шинжлэх ухааны чиглэлээр эрдэм судлалын ажлыг үндэсний хэмжээнд зохицуулах Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг төвийн Ерөнхий захирал батлана.

5. Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

6. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, санал гомдлын хороо болон бусад шаардлагатай хороог байгуулан ажиллуулна.

## 7. Ерөнхий захирлын эрх, үүрэг

7.1. Төвийг удирдлага зохион байгуулалтаар хангах, Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

7.2. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах;

7.3. Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ойрын болон хэтийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

7.4. Тасгийн эрхлэгч, албадын дарга, нэгжийн удирдлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

7.5. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажиллагсадын цалин хөлсийг тогтоох;

7.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах;

7.7. Засгийн газрын мэрийн хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, опон улсын төсөл хөтөлбөр, төрийн захиргааны төв байгууллагын гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам, албан даалгаврын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

7.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;

7.9. Төсвийг хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах.

## Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1. Улсын төсөв;

2. Үндсэн /төлбөртэй тусlamж үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх/ ба туслах үйл ажиллагааны орлого /байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжинд нийцүүлэх вж өхүүн үйл ажиллагаа явуулж олсон орлого гэх мэт/

3. Төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусlamж;

4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

### **Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа**

1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд ерөнхий захирал төлөөлнө.

2. Төвийн ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг ерөнхий захирал шийдвэрлэнэ.

4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлагууд, газрын дарга настай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

### **Долоо. Төвийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

Төв нь дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

1. Улс төр, шашны зорилготой үйл ажиллагаа зохион байгуулах;
2. Хууль тогтоомжинд зааснаас бусад хэлбэрээр орлого олох үйл ажиллагаа явуулах;
3. Хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

### **Найм. Төвийн алба, тасаг нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг**

#### **8.1. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитор**

Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, дунд урт хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, төвийн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх;

Хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээний дунд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа сайжруулах зөвлөмж гаргах, гүйцэтгэлийн хяналт хийх, хөндлөнгийн хяналтыг аудитын байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах.

#### **8.2. Чанар, цусны сонор сээрэмжийн алба**

Цусны албаны үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, тусlamж үйлчилгээний чанарт дотоод хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

Чанар, цусны сонор сээрэмжийн алба нь улсын хэмжээнд донорын үйл ажиллагаанд гарч болох бүхий л эрсдэлээс сэргийлэх тогтолцоог нэвтрүүлэх, цус сэлбэлттэй холбоотой урвал, хүндрэлийг бүртгэх, шалтгааныг тогтоох, эргэн мэдээлэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд цусны сонор сээрэмжийн тогтолцоог нэвтрүүлж, хяналт үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах;

Цусны салбар төв болон эмнэлгийн байгууллагууд, алба, тасаг нэгжүүдтэй хамтран ажиллах, стандарт, удирдамж, заавруудыг мөрдүүлэх, зөвлөн туслах, чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж үр дүнг тооцох.

### **8.3. Стратеги төлөвлөлт, санхүү, бүртгэлийн алба**

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, хэтийн зорилтыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, хяналт тавих;

Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч ажиллах;

Төвийн нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн хүрээнд шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах;

Санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Төвийн болон албаны үйл ажиллагааны статистик мэдээ мэдээллийг гаргах, тайлан мэдээг нэгтгэн дүгнэх, тайлагнах, өөрийн харьяа байгууллага, нэгжүүдэд бүртгэл, мэдээллийн талаар сургалт хийх, бүртгэл мэдээллийн байдалд хяналт тавих, цахим бүртгэл, бодит мэдээллийг нэвтрүүлэх, алсын зайн сургалтыг нэвтрүүлэх;

Эмнэлгийн хэрэгсэл, бараа, материалын нөөцийг зохистой бүрдүүлэлт, ажиллагсад болон донорын хоол бэлтгэлийн чанар, аюулгүй байдлыг хангах, барилга байшин, эд хогшил, автомашины бэлэн байдлыг хангах, гадна болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хийх;

Эмнэлгийн багаж хэрэгсэл, зөвлөн өдлэлийн ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, төвийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, ажилтан, үйлчлүүлэгчдийг халдварт өртөх эрсдлээс сэргийлэх;

Төвийн цахилгаан, дулааны хэвийн үйл ажиллагааг хангах, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх, зохион байгуулах, сантехник, цахилгааны засвар үйлчилгээг тогтмол хийх үйл ажиллагааг хариуцах.

### **8.4. Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба**

Монгол улсын шинжлэх ухаан технологийн хөгжлийн бодлого, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн төвийн эрдэм шинжилгээ, судалгааны хөгжлийн бодлогыг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалт сурталчилгааг зохион байгуулах;

Төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж, төвийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг мэргэжил, арга зүйгээр ханган хөгжүүлэх;

Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангалт, хуваарилалт, байршуулалт хийх;

Төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх;

Ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлж, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

### **8.5. Сувилахуйн алба**

Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн хяналтын хуудсыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх;

Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварт хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулан арга, зүйгээр хангаж ажиллах.

### **8.6. Донор зохион байгуулалтын тасаг**

Хүн амын дунд сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах, донор элсүүлэх, цус, сийвэн, эс цуглуулах, донор хадгалалтыг сайжруулах, донорын бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

Цусны донорын сонор сээрэмжийг тогтолцоог хэрэгжүүлэх, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, төвийн яаралтай тусламжийн хэсгийг хариуцан ажиллах.

### **8.7. Технологийн тасаг**

Цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шинэ арга, технологи нэвтрүүлэх, стандартын дагуу чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, стандартын дагуу зөв хадгалах, тээвэрлэх;

Гамшгийн нөөц бүрдүүлж нөхөн хангалтыг зохицуулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, устгал, захиалгын бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, цахимжуулах, чанарын шаардлага хангасан аюулгүй, найдвартай цус, цусан бүтээгдэхүүнээр эмнэлгийн захиалгын дагуу тэгш хүртээмжтэй хангах.

### **8.8. Нэгдсэн лабораторийн тасаг**

Цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдварт илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох шинжилгээ болон үйлдвэрлэсэн цус цусан бүтээгдэхүүнд чанарын хяналтын шинжилгээ, цусны ховор бүлгийн шинжилгээг стандартын дагуу бүрэн зөв хийх, шинжилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх;

Цус сэлбэлтээр дамждаг халдварт илрүүлэх болон цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, иммуногематологийн чиглэлээр лавлагaa тусламж үйлчилгээ үзүүлэх, шинжилгээний бүртгэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, хувь хүний нууцыг хадгалах, зөвшөөрөгдсөн төлбөрт шинжилгээг хийх.

### **8.9. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасаг**


Мэдээллийн техник, хэрэгслийн засвар үйлчилгээг хариуцан тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангах, доголдол, гэмтэл гарсан үед оношилж, засварлах, техник хэрэгсэлд ашиглалтын карт хөтлөх, байгууллагын хэмжээнд хорт кодын (вирус) эсрэг программ, хангамжийг сонгон суурилуулах, өгөгдлийн сүлжээ, программ хангамжуудын хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутаг дахь цусны албадын мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагааг хангах.

Төвийн оношлогоо, үйлчилгээнд хэрэглэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай, бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийх, сэлбэгийг нөөцлөх, тогтмол хяналт хийж шинэчлэх асуудлыг зохицуулах, ашиглалтын паспортыг тогтмол шалгах, шинэ багаж тоног төхөөрөмж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сан бүрдүүлж удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдийг шаардлагатай мэдээллээр хангах;

### **Ес. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах**

Төвийн ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэнд, спортын сайдын тушаалаар дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС  
ХОЛБОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖИЛ  
АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ**



**Мэргэжил арга зүйн шууд удирдлага**

**----- Мэргэжил арга зүйн шууд бус удирдлага -----**

Эрүүл мэнд спортын сайдын  
2016 оны 04 сарын 22 өдрийн  
1131 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

